ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ЗАА-2026/212/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Улиастай сум
2026 он


Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Оюунсувд

Утас: 99076038

Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....8

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11

4. Аудитын тайлан.....13

4.1 Ерөнхий зүйл .....13

4.2 Материаллаг байдал .....14

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....14

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....14

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....15

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....16

5. Аудитын илрүүлэлт .....16

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт


ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Улиастай сум, Завхан аймаг 81090
Утас/Факс:7046-36-12
Цахим шуудан: zavkhan@audit.gov.mn


2026.02.25 № 191

танай ______ -ны № ______ -т

АЛДАРХААН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.ТӨМӨРХҮҮ-д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 51,280.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5,388,306.1 мянган төгрөгийн авто зам, “Адап” төслөөс 105,000.0 мянган төгрөгийн контейнер, 64,042.6 мянган төгрөгийн бэлчээрийн худаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 39,576.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, бүртгэлд тусгасан байна. Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны А/94 дүгээр захирамжаар 162,437.9 мянган төгрөгийн Ланд-200 автомашиныг аймгийн Байгаль орчны газарт балансаас балансд шилжүүлж, аймгийн Засаг даргын Тамгын газраас шилжиж ирсэн 19,000.0 мянган төгрөгийн суудлын автомашиныг данс бүртгэлд тусгажээ.

Аудитын гол асуудал

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар Засаг даргын нөөц хөрөнгөөс 7,850.0 сая төгрөгийг, аймгийн Засаг

даргын захирамжаар олгосон 5,000.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, 17,375.9 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй, зардал хооронд гүйлгэн зарцуулсан, ёс зүйн хорооны гишүүдэд 2,138.4 мянган төгрөгийн урамшуулал олгож, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газар нь шилэн дансны цахим системд 2,675,932.2 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй, 279,551.6 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 7,100,000.00 | 8,550,000.00 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 7,100,000.00 | 8,550,000.00 |
| **3121** | **Төгрөг** | 7,100,000.00 | 8,550,000.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 7,100,000.00 | 0.00 |
| 31218 | Ахмадын сангийн харилцах | 0.00 | 8,550,000.00 |
| **33** | **АВЛАГА** | 0.00 | 64,522,371.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 0.00 | 842,771.00 |
| **335** | **Бусад авлага** | 0.00 | 63,679,600.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 0.00 | 63,679,600.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 83,288,751.00 | 93,879,700.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 6,526,955.00 | 5,581,250.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,526,955.00 | 5,581,250.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 76,761,796.00 | 88,298,450.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,117,700.00 | 1,780,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,710,520.00 | 10,157,850.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,051,426.00 | 0.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 3,000.00 | 2,058,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 62,879,150.00 | 74,302,600.00 |
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **90,388,751.00** | **166,952,071.00** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,481,266,383.11 | 6,731,002,187.86 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,392,889,303.11 | 6,642,762,607.86 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,014,972,946.48 | 1,184,015,559.48 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -406,690,486.57 | -457,444,858.26 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 418,617,960.45 | 275,180,063.80 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -94,663,321.44 | -117,827,484.12 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 551,147,691.00 | 626,490,975.93 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -265,371,962.57 | -306,468,254.64 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 21,282,600.00 | 23,950,377.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -8,992,338.06 | -12,109,016.22 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 0.00 | 5,388,306,087.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | -103,621,270.89 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 209,278,943.00 | 227,679,143.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -47,407,184.18 | -86,103,169.22 |
| 39217 | Ном | 714,455.00 | 714,455.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 88,377,080.00 | 88,239,580.00 |
| 39301 | Программ хангамж | 2,602,000.00 | 2,602,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,464,500.00 | -2,602,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 88,239,580.00 | 88,239,580.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,481,266,383.11** | **6,731,002,187.86** |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,571,655,134.11** | **6,897,954,258.86** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,837,014.83 | 787,900.00 |
| **413** | **Өглөг** | 1,837,014.83 | 787,900.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.00 | 580,600.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 696,958.00 | 207,300.00 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,837,014.83** | **787,900.00** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,569,818,119.28 | 6,897,166,358.86 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 448,989,594.69 | 448,989,594.69 |
| 511001 | Засгийн газрын оруулсан капитал загийн газрын сан | 448,989,594.69 | 448,989,594.69 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,056,070,805.85 | 6,383,419,045.43 |

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 405,870,501.80 | 1,056,070,805.85 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 650,200,304.05 | 5,327,348,239.58 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 64,757,718.74 | 64,757,718.74 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,569,818,119.28** | **6,897,166,358.86** |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,571,655,134.11** | **6,897,954,258.86** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* * /төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,005,134,772.00** | **1,078,273,791.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 34,138,772.00 | 91,500,052.70 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 33,071,857.00 | 90,177,877.70 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,066,915.00 | 1,322,175.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 970,996,000.00 | 986,773,738.30 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 970,996,000.00 | 986,773,738.30 |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | **747,229,548.80** | **5,654,710,115.21** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 747,229,548.80 | 5,654,710,115.21 |
| 120009 | Бусад орлого | 5,200,000.00 | 16,160,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 739,279,948.80 | 5,618,550,115.21 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 2,749,600.00 | 20,000,000.00 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,752,364,320.80** | **6,732,983,906.21** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,102,164,016.75** | **1,250,968,166.74** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 947,721,954.08 | 1,197,014,654.95 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 466,108,375.33 | 579,733,409.13 |
| 210101 | Үндсэн цалин | 306,570,082.66 | 340,205,523.26 |
| 210102 | Нэмэгдэл | 146,204,492.67 | 167,631,253.91 |
| 210104 | Урамшуулал | 6,293,800.00 | 23,365,662.96 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 7,040,000.00 | 48,530,969.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 72,044,496.83 | 77,677,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 49,183,596.83 | 52,782,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,715,300.00 | 6,214,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,360,000.00 | 3,144,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,355,200.00 | 3,107,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,430,400.00 | 12,428,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 57,392,800.00 | 54,118,838.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,439,618.31 | 17,622,328.33 |
| 210302 | Түлш, халаалт | 42,953,181.69 | 36,496,510.62 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 51,993,977.40 | 81,399,496.20 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,481,080.00 | 10,208,180.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 42,565,877.40 | 38,649,941.20 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,376,170.00 | 2,873,750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,570,850.00 | 5,312,300.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0.00 | 24,355,325.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,815,850.00 | 8,357,022.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,815,850.00 | 8,357,022.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,366,000.00 | 4,650,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,366,000.00 | 4,650,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,457,100.00 | 2,581,811.50 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,239,500.00 | 2,156,112.50 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469,100.00 | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227,700.00 | 336,699.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 73,800.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 89,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,447,000.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 288,543,354.52 | 388,496,677.17 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 136,327,451.00 | 119,916,366.60 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 170,000.00 | 823,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 152,045,903.52 | 267,756,810.57 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 154,442,062.67 | 53,953,511.79 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 14,698,047.50 | 10,832,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 10,332,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 14,698,047.50 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.00 | 500,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 139,744,015.17 | 43,120,611.79 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 139,744,015.17 | 31,488,036.79 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 11,632,575.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,102,164,016.75** | **1,250,968,166.74** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **650,200,304.05** | **5,482,015,739.47** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 0.00 | 152,337,499.89 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | 0.00 | 2,330,000.00 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 0.00 | 154,667,499.89 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН** | 0.00 | -154,667,499.89 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **650,200,304.05** | **5,327,348,239.58** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *(/төгрөгөөр/)*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,005,134,772.00** | **1,078,273,791.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 34,138,772.00 | 91,500,052.70 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 33,071,857.00 | 90,177,877.70 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,066,915.00 | 1,322,175.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 970,996,000.00 | 986,773,738.30 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 970,996,000.00 | 986,773,738.30 |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | **5,200,000.00** | **16,160,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,200,000.00 | 16,160,000.00 |
| 120009 | Бусад орлого | 5,200,000.00 | 16,160,000.00 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **1,010,334,772.00** | **1,094,433,791.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **980,185,472.00** | **1,041,703,791.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **825,743,409.33** | **987,750,279.21** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 466,108,375.33 | 581,716,236.96 |
| 210101 | Үндсэн цалин | 306,570,082.66 | 342,188,351.09 |
| 210102 | Нэмэгдэл | 146,204,492.67 | 167,631,253.91 |
| 210104 | Урамшуулал | 6,293,800.00 | 23,365,662.96 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 7,040,000.00 | 48,530,969.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 70,904,440.00 | 77,677,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,043,540.00 | 52,782,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,715,300.00 | 6,214,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,360,000.00 | 3,144,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,355,200.00 | 3,107,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,430,400.00 | 12,428,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 57,812,800.00 | 56,898,438.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,659,618.31 | 17,622,328.33 |
| 210302 | Түлш, халаалт | 43,153,181.69 | 39,276,110.62 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33,861,927.00 | 34,367,645.20 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,268,500.00 | 5,320,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,093,357.00 | 23,061,315.20 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,376,170.00 | 3,349,130.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,123,900.00 | 2,636,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,792,800.00 | 26,643,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 190,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,792,800.00 | 26,453,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,366,000.00 | 4,650,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,366,000.00 | 4,650,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,910,315.00 | 3,222,211.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,490,715.00 | 2,156,112.50 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469,100.00 | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227,700.00 | 336,699.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 73,800.00 | 640,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 202,000.00 | 89,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,447,000.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 184,986,752.00 | 202,574,746.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 184,083,452.00 | 201,681,746.60 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 903,300.00 | 893,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **154,442,062.67** | **53,953,511.79** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 14,698,047.50 | 10,832,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 10,332,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 14,698,047.50 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.00 | 500,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 139,744,015.17 | 43,120,611.79 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 139,744,015.17 | 31,488,036.79 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 11,632,575.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН** | **980,185,472.00** | **1,041,703,791.00** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **30,149,300.00** | **52,730,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **27,349,300.00** | **51,280,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 27,349,300.00 | 51,280,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 27,349,300.00 | 51,280,000.00 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **27,349,300.00** | **51,280,000.00** |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-27,349,300.00** | **-51,280,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 2,800,000.00 | 1,450,000.00 |
| **14** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 4,300,000.00 | 7,100,000.00 |
| **15** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 7,100,000.00 | 8,550,000.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 448,989,594.69 | 64,757,718.74 | 405,870,501.80 | 919,617,815.23 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **448,989,594.69** | **64,757,718.74** | **405,870,501.80** | 919,617,815.23 |
| C09 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 650,200,304.05 | 650,200,304.05 |
| C10 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **448,989,594.69** | **64,757,718.74** | **1,056,070,805.85** | 1,569,818,119.28 |
| C11 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **448,989,594.69** | **64,757,718.74** | **1,056,070,805.85** | 1,569,818,119.28 |
| C13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **448,989,594.69** | **64,757,718.74** | **1,056,070,805.85** | 1,569,818,119.28 |
| C19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 5,327,348,239.58 | 5,327,348,239.58 |
| C20 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **448,989,594.69** | **64,757,718.74** | **6,383,419,045.43** | 6,897,166,358.86 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| ЭЗА | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **12200** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 1,007,625,536.40 | 955,285,701.51 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 1,007,625,536.40 | 955,285,701.51 |
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | 1,007,625,536.40 | 955,285,701.51 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,007,625,536.40 | 959,035,701.51 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 989,532,636.40 | 948,202,801.51 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 617,966,500.00 | 581,716,236.96 |
| 210101 | Үндсэн цалин | 429,345,500.00 | 342,188,351.09 |
| 210102 | Нэмэгдэл | 132,244,400.00 | 167,631,253.91 |
| 210104 | Урамшуулал | 45,825,000.00 | 23,365,662.96 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 10,551,600.00 | 48,530,969.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 77,677,400.00 | 77,677,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,820,600.00 | 52,782,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,214,200.00 | 6,214,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,107,100.00 | 3,144,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,107,100.00 | 3,107,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,428,400.00 | 12,428,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 57,308,600.00 | 56,898,438.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,503,600.00 | 17,622,328.33 |
| 210302 | Түлш, халаалт | 50,805,000.00 | 39,276,110.62 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33,450,080.00 | 33,308,080.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,373,100.00 | 5,418,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,903,450.00 | 21,903,350.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,536,630.00 | 3,349,130.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,636,900.00 | 2,636,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 77,825,200.00 | 77,825,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 51,281,600.00 | 51,281,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 26,543,600.00 | 26,543,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,650,000.00 | 4,650,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,650,000.00 | 4,650,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,266,099.00 | 2,266,099.00 |
| 210801 | Мэргэжлийн үйлчилгээний төлбөр | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо | 336,699.00 | 336,699.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 640,400.00 | 640,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 89,000.00 | 89,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 118,388,757.40 | 113,861,346.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 117,495,757.40 | 112,968,346.60 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 893,000.00 | 893,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 18,092,900.00 | 10,832,900.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,092,900.00 | 10,832,900.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 7,260,000.00 | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 10,332,900.00 | 10,332,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 500,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | 1,007,625,536.40 | 959,035,701.51 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 7,100,000.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.00 | 8,550,000.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **90,827,477.70** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **90,827,477.70** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 90,827,477.70 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.00 | 1,157,965.20 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 1,157,965.20 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 0.00 | 956,112.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 956,112.50 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 88,713,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 88,713,400.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 90,827,477.70 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 90,827,477.70 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 89,997,877.70 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 829,600.00 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:** Аудитаар нийт 3,235,078.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 247,230.5 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 2,138.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 12,850.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 17,375.9 мянган төгрөгийн болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2,955,483.8 мянган төгрөгийн зөрчилд 2 заалт зөвлөмж хүргүүллээ.

**3.1 Аудитын залруулга:** ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 64,042.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн тодруулга тайланд зөв ангилж бүртгээгүй, тайлант онд худалдаж авсан 1,750.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн, аймгийн ИТХ-ын даргын 2025 оны А/94 дүгээр захирамжаар Байгаль орчны газарт балансаас балансt шилжүүлсэн 162,437.9 мянган төгрөгийн автомашиныг данс бүртгэлээс хасаагүй, аймгийн ИТХ-ын даргын 2025 оны А/94 дүгээр захирамжаар АЗДТГ-аас балансаас балансt шилжиж ирсэн 19,000.0 мянган төгрөгийн суудлын автомашиныг данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д "Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана.", 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн

тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.2 Төлбөрийн акт:** Ёс зүйн хорооны гишүүдэд 2,138.4 мянган төгрөгийн урамшуулал олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

**3.3 Албан шаардлага:** Засаг даргын нөөц хөрөнгөөс нутгийн зөвлөлийн золголт, говийн бүсийн спортын наадмын зардал, Ерөнхий боловсролын сургууль болон нисэх хүчин үүсэн байгуулагдсаны ойн арга хэмжээний хандив, аймгийн арсланд хүндэтгэл үзүүлэх зэрэгт 7,850.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, аймгийн Засаг даргын захирамжаар олгосон Алдархаан сумын иргэдэд сургалт, мэдээлэл хүргэх, уул уурхайн чиглэлээр хэлэлцүүлэг хийх арга хэмжээний зардалд зарцуулах 5,000.0 мянган төгрөгийг кассын дансаар дамжуулан зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй зөрчил албан шаардлага өгсөн.

**3.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***<u>Илрүүлэлт</u>***: Зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй 17,357.9 мянган төгрөгийн зардал хооронд гүйлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасныг зөрчиж, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
***<u>Өгсөн зөвлөмж</u>***: Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, шаардлагатай тохиолдолд төсөвт зохицуулалт хийж байх;

***2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***<u>Илрүүлэлт</u>***: Батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулсан шийдвэрийг бүрэн мэдээлээгүй байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад мэдээлсэн байдлын хэрэгжилт 32.5 хувь, хугацаа хоцролтын хэрэгжилт 80 хувьтай байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4-д "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2.2.1.6-д "төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт", 2.2.1.13-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, зарлагын гүйлгээ бүр, холбогдох шийдвэрийн хуулбарын хамт", 2.2.2.1-д "худалдан авах ажиллагааны төлөвлөгөө", 2.2.2.2-д "худалдан авах ажиллагааны тайлан", 2.2.3.2-т "зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", 3.2-д "Төсвийн байгууллага дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд

мэдээлнэ", 3.2.1-д "худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг энэ журмын 21 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, жилийн тайланг энэ журмын 22 дугаар хавсралтад заасан маягтын дагуу дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор тус тус цахимаар", 3.2.10-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар", 3.2.11-д "зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Шилэн дансны цахим системд төсөв санхүүгийн мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, иж бүрэн мэдээлж хэвших, 6.1.1 дэх хэсэгт байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг, 6.1.5 дахь хэсэгт аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг", 6.4.5 дахь хэсэгт цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээг", 6.4.8 дахь хэсэгт төсөв, өмч, хөрөнгө зарцуулах гэрээ болон шийдвэрийг тухай бүр мэдээлж байх;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 25-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитаар илрүүлсэн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**
**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон үндсэн хөрөнгийг санхүүгийн тодруулга тайланд зөв ангилж бүртгээгүй байна. | 1 | 64,042.6 | | | 1 | 64,042.6 | 1 | 64,042.6 | | | | |
| Тайлант онд худалдаж авсан хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн. | 1 | 1,750.0 | | | 1 | 1,750.0 | 1 | 1,750.0 | | | | |
| Аймгийн ИТХ-ын даргын 2025 оны А/94 дүгээр захирамжаар Байгаль орчны газарт балансаас балансt шилжүүлсэн автомашиныг данс бүртгэлээс хасаагүй байна. | 1 | 162,437.9 | | | 1 | 162,437.9 | 1 | 162,437.9 | | | | |
| Аймгийн ИТХ-ын даргын 2025 оны А/94 дүгээр захирамжаар АЗДТГ-аас балансаас балансt шилжиж ирсэн суудлын автомашиныг данс бүртгэлд тусгаагүй байна. | 1 | 19,000.0 | 1 | 19,000.0 | | | 1 | 19,000.0 | | | | |
| **Дүн** | **4** | **247,230.5** | 1 | 19,000.0 | **3** | **228,230.5** | **4** | **247,230.5** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | АТТ | Тоо | Дүн |
| Засаг даргын нөөц хөрөнгөөс нутгийн зөвлөлийн зөлголт, говийн бүсийн спортын наадмын зардал, ЕБС болон нисэх хүчин үүсэн байгуулагдсаны ойн арга хэмжээний хандив, аймгийн арслан хүндэтгэл үзүүлэхэд эмээл худалдах авах зэрэгт 7.85 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. | 1 | 7,850.0 | | | 1 | 7,850.0 | | | | | | |
| Аймгийн Засаг даргын захирамжаар Алдархаан сумын иргэдэд сургалт, мэдээлэл хүргэх, уул уурхайн чиглэлээр хэлэлцүүлэг хийх арга хэмжээний зардалд зарцуулах 5.0 сая төгрөгийг кассын дансаар дамжуулан зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй байна. | 1 | 5,000.0 | | | 1 | 5,000.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ёс зүйн хорооны гишүүдэд урамшуулал олгож, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн байна. | 1 | 2,138.4 | 1 | 2,138.4 | | | | | | | | |
| Зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй зардал хооронд гүйлгэн зарцуулсан байна. | 1 | 17,375.9 | | | | | 1 | 17,375.9 | | | | |
| Шилэн дансны цахим системд 2,675.9 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй, 279.5 сая төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроосон байна. | 1 | 2,955,483.8 | | | | | 1 | 2,955,483.8 | | | | |
| **Дүн** | **5** | **2,987,848.1** | **1** | **2,138.4** | **2** | **12,850.0** | **2** | **2,972,859.7** | | | | |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР

Огноо: 2026-02-25

**БОЛОВСРУУЛСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

Огноо: 2026-02-25